

2026 он 06 сар 17 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Говь ХК (“Компани”)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.7.15, 6.2.7.17 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Таван Богд Холдингс” ХХК-ийн “Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк” (цаашид “ЕСБХБ” гэх)-тай байгуулах 25,000,000 (хорин таван сая) евротой тэнцэх төгрөг хүртэлх дүн бүхий зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Компанийн ЕСБХБ-тай 2025 оны 05-р сарын 30-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулсан Хавсралт 1-т заасан хөрөнгүүдийг ЕСБХБ эсхүл түүнийг албан ёсоор төлөөлөх, нэрлэн заасан этгээдэд нэмж барьцаалуулах, холбогдох барьцааны гэрээнүүдийг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан барьцааны гэрээнүүдийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, улмаар тус барьцааны гэрээнүүдэд Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаараа эсвэл хамтран хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан), “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарт тус тус олгосугай.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР